

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2018ОНЫ ХАГАСЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2018 оны 6-р сарын 12-ны өдөр

Мандалговь

2018 онд тус хэлтэс нь дарга, үндсэн мэргэжилтэн 4, судлаач 3, нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж дараах ажил үүргийг гүйцэтгэлээ.

МУ-ын Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон, ҮСХ-ны дарга, аймгийн Засаг дарга, Статистикийн хэлтсийн дарга нарын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ, 2018 оны жилийн ажлын төлөвлөгөө, удирдлагуудаас өгсөн ажлын чиглэл, тогтоол шийдвэрүүдийг үндэслэн албан ёсны статистикийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, үнэн зөв, шуурхай бодит байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулах, судалгааны чанарыг сайжруулах, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэн идэвхи санаачлага, бүтээлч ажиллагааг эрчимжүүлэх, аймгийн хөдөө аж ахуйн байдал, хүн ам, нийгэм, эдийн засгийн чиглэлээр танилцуулга бэлдэх, хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сан, бизнес регистрийн сангийн хөтлөлтийг сайжруулах, мэдээллийн технологи портал вэб сайтын баяжилтыг хангах, хэрэглэгчдэд үйлчлэх зорилтуудыг өмнөө тавьж амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

I БҮЛЭГ: АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

1.МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)

Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны 12 сарын 18-ны А/203 тоот тушаалаар батлагдсан 2018 оны албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг мөрдөж, оны эхэнд ирсэн хүрээгээр аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулж, 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 15 сумын давхардсан тоогоор 880 аж ахуй нэгжийг хамруулах ёстойгоос 880 аж ахуй нэгжийг хамруулж мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан. Үүнээс мал эмнэлгийн 26, тээвэр 1, холбооны 3, аж үйлдвэрийн 9, зочид буудлын 5, зоогийн газрын 16, төрийн бус байгууллагын 9, сүм хийдийн 8, аялал жуулчлалын 11, барьцаалан зээлдүүлэхийн 15, худалдааны 61, нийгэм бие хүний мэдээ 2, мэргэжлийн түр сургалтын 3, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагын 1, соёл, биеийн тамир спортын 1, сонин сэтгүүлийн 1, хөрөнгө оруулалтын 5, барилгын 11, салбарын үнийн судалгааны 15, жилийн эцсийн аж ахуйн нэгжийн мэдээгээр 380 газраас мэдээг авч бүрэн хамруулсан байна.

Мэдээний хүрээнд зайлшгүй өөрчлөлт орох тохиолдолд холбогдох газар, хэлтсийн мэргэжилтэнтэй тохирч байгаа учир мэдээний хамралт 100 хувьтай байгаа юм. 2018 оны эхний хагас жилийн байдлаар мэдээний тасалдал, хожимдол гаргаагүй, мэдээний графикт өдрийн 17 цагт багтаан мэдээг бүрэн оруулж нэг бүрчлэн шалгаж, мэдээ мэдээллийн чанарын асуудалд анхаарлаа хандуулан, хамралт бүрэн байгаа эсэхийг хянан дамжуулдаг.

2. МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)

2018оны эхний хагас жилийнбайдлаар ҮСХ-д мэдээг 100 хувь хугацаанд нь гаргаж, дамжуулбал зохих графикт өдөр нь бүрэн дамжуулсан. Тухайн тайлант үед мэдээ дамжуулах, онлайн програмд шивэлт хийхэд ямар нэг саатал гараагүй үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Сар бүрийн 1, 4, 5, 8, 21-нд сард 5 удаа мэдээ дамжуулж байна. Мөн 7 хоног бүрийн 3 дахь өдөр үнийн мэдээг аймгийн төвийн зах, дэлгүүрүүдээс авч тогтмол дамжуулж хэвшсэн.

Мэдээнүүдийг програмын дагуу шивж, алдааг бүрэн засварлан үр дүнгийн хүснэгтийг үүсгэн өнгөрсөн мөн үе болон өмнөх сарын мэдээтэй уялдуулан шалгаж, тодруулах шаардлагатай мэдээг ААНэгжүүдээсээ тодруулан шалгадаг.

Нийт 58 нэрийн давхардсан тоогоор 1835мэдээг 100 хувьхугацаанд нь бүрэн интернетээр дамжуулсан. Үүнд хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2мэдээг 66 багаас нийт 660 мэдээг, ХАА-3, ХАА-6,НҮ-1,НЗҮ-1 мэдээнүүдийг 15 сумаас нийт150 мэдээг, аж үйлдвэрийн мэдээг сар бүр 9 ААН-с нийт 51 мэдээ, тээврийн 4, зочид буудал, зоогийн газрын 42, худалдааны 90, төрийн бус байгууллагын 18, мал эмнэлгийн 52, сүм хийдийн 16, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний 30, мэргэжлийн түрсургалтын 6, холбооны 6, бизнес регистрийн 14 аж ахуйн нэгжийн мэдээллийг, хүн амын ХА-3 мэдээг 66 багаас 1 удаа, ХА-2, ХА-1 мэдээг нэг удаа, ОС-1 мэдээгээр 69, барилгын 22, хөрөнгө оруулалтын 5, хэрэглээний үнийн сарын мэдээг сар бүр 5 сумаас 90 мэдээ, үйлчилгээний салбарын үнийн 10, худалдааны салбарын үнийн мэдээг сар бүр 4 ААН-с нийт 24 мэдээг тус тус тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээллээ.Үүн дээр 2018 оны 5 сарыг хүртэлОУ-ын Өртгийн зэрэгцүүлэлтийн үнийнмэдээнд 8 сар хүнс, ундаа , архины салбарын 125 нэрийн барааны үнийг 3 цэгээс авч, 2 улирал 12 салбарын 450 нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг 3 цэгээс авч программд шивэн хугацаанд нь дамжууллаа. Сонгогдсон аж ахуйн нэгж тухайн сар, улиралд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулаагүй тохиолдолд тайлбарыг мэдээний хамт явуулж байлаа.

3. МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (ШЗ)

ҮСХ-нд дамжуулах мэдээ тайланг салбар хариуцсан мэргэжилтнүүд сумд болон мэдээлэгчдээс шалган авч програмд боловсруулсны дараа хэлтсийн ахлах мэргэжилтэн хүлээн авч логик шалгалтуудыг хийж өнгөрсөн оны болон өмнөх сарын гүйцэтгэлүүдтэй зэрэгцүүлэн үзэж баталгаажуулан төвд мэдээлж байснаар мэдээ тайлангийн алдаагүй ажиллаж байна.


Тус хэлтэс 2018 оныг сумдын анхан шатны мэдээний бүртгэл хөтлөлт, баримтжуулалт, Багийн засаг дарга нарын чадавхийг сайжруулах чиглэлээр түлхүү ажиллах жил болгосон бөгөөд энэ ажлын хүрээнд эхний хагас жилд хяналт шинжилгээний төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа.

Статистикийн хэлтэс, Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газруудтай хамтарсан Хяналт шалгалтын удирдамж батлан Цагаандэлгэр, Говь-угтаал, Хулд, Луус сумдад анхан шатны статистик мэдээг сайжруулах талаар хамтарсан хяналт шалгалтыг нийт 16 байгууллагад зохион байгуулж, дүгнэлт зөвлөмжийг хүргүүлээд байна.

Сумдын статистик хариуцсан ажилтнууд болон Багийн засаг дарга нарын анхан шатны мэдээний чанарыг сайжруулж бодит байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Луус, Хулд, Өлзийт, Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдын нийт 53 хүнийг хамруулан хяналт шалгалт хийж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгавар өгөөд байна.

4. ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)

ХАӨМСангийн чанарыг сайжруулах, багийн ЗДарга, төрийн сангийн мэргэжилтэний үр дүнгийн гэрээнд мэдээллийн сангийн талаар зүйл заалтыг тодорхой оруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байхыг тусгасан 04 тоот албан бичгийг талаар сумдын Засаг дарга нарт оны эхэнд хүргүүлсэн.




**ДУНГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**
48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас: 70-59-37-15, 70-59-37-14

2018. 01.25 № 04
тантай _____ -ны № _____ -т

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

Сумдын ХАӨМСангийн мэдээлэл шинэчлэгдэхгүй үр дүнгийн хүснэгт гаргахад зөрүүтэй гарах зэрэг дутагдалтай байна.

Иймд Багийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээ, ажлын төлөвлөгөөнд хүн ам өрхийн мэдээллийг тогтмол баяжуулан алдааг тухай бүр засварлуулах, өдөр тутмын ажилдаа тогтмол ашиглаж хэвших, мөн сар бүр явагддаг ажиллах хүчний судалгаа, өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны нэрсийг хугацаанд нь үнэн зөв хүргүүлж байх талаар тусган ажиллахыг хүсье.


ДАРГА  Б.ЭНХТУЯА
4818129024
UL_ZIOA0028 9033777

ХАӨМСанд дараах чиглэлээр 7 хоног тутамд хяналт тавин ажиллаж байна.

- Шинэ төрсөн болон нас барсан хүний мэдээллийг бүртгэсэн эсэх
- Мэдээллийн сангийн алдааг засварласан эсэх



- Шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж буй эсэх
- Өрхийн үзүүлэлтийг оруулан газрын зурагт тэмдэглэсэн эсэхийг хянаж тухай бүр багийн засаг дарга нарт үүрэг чиглэл өгч байна.

Үүнээс гадна өрх, хүн амын хувийн үзүүлэлт өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлтийг тогтмол хийж мэдээллийн чанарт анхаарч ажиллах талаах сум багийн удирдлагуудад үүрэг өгч ажилласан. Мөн багийн засаг дарга нарын ажил дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж нийт үнэлгээний 25 хувийг ХАӨМСангийн ажлаар дүгнэхээр болсон. 2018 оны эхний хагас жилийн байдлаар бүх багийн ХАӨМСанд дээрх 4 чиглэлээр хяналт хийж үнэлгээ гарган сумдад хүргүүлэн 7 сарын 1 ны дотор бүрэн засварлах чиглэл өглөө.

Сум	Баг	Хүн	Өрх	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь	Хүн амын хувь
Өндөршил сум	1-р баг, Цог	51	9	4.5	5	4.8	23.3	2	1	0	10	1	
	2-р баг, Талын нар	53	10	4.5	5	5	24.5	0	1	0	1	1	
Сайнцагаан сум	1-р баг, Наран	51	9	5	5	5	24	1	0	1	3	0	
	2-р баг, Тэвш	53	10	5	4.5	5	24.5	0	0	4	2	0	
	3-р баг, Далай	55	10	4	4	4.5	22.5	0	6	11	22	1	
	4-р баг, Үйзэн	57	9	4	4.5	4.5	22	2	5	4	16	8	
	5-р баг, Дривжих	59	10	5	5	4.8	24.8	0	0	0	15	1	
	6-р баг, Боржигон	61	10	5	5	4.5	24.5	0	0	1	22	2	
	7-р баг, Нарлаг	63	10	5	5	4.5	24.5	0	0	1	52	3	
	8-р баг, Айраг	65	10	5	5	4.5	24.5	0	0	0	31	5	
	9-р баг, Мандал	67	10	5	5	4.5	24.5	0	0	1	20	11	
Сайхан-Овоо сум	1-р баг, Онги	51	10	5	5	4.9	24.9	0	0	0	6	0	
	2-р баг, Мааньт	53	10	5	5	4.8	24.8	0	4	0	9	6	
	3-р баг, Найз	55	10	4	4	4.8	22.8	0	0	5	9	3	
	4-р баг, Төгрөг	57	10	5	5	5	25	0	0	0	3	0	
Хулд сум	1-р баг, Шувуутай	51	10	5	5	5	25	0	0	0	3	0	
	2-р баг, Олдох	53	10	5	4.5	4.9	24.4	0	0	2	3	4	
	3-р баг, Уул	55	9	5	5	4.9	23.9	2	0	0	8	1	
	4-р баг, Бүлээн	57	10	5	5	5	25	0	0	0	1	2	
Цагаандэлгэр сум	1-р баг, Хараат	51	10	5	5	5	25	0	0	0	3	1	
	2-р баг, Дэлгэрэх	53	10	5	5	5	25	0	0	0	2	0	
	3-р баг, Жаргалант	55	9	5	4	4.8	22.8	1	0	5	7	3	
	4-р баг, Замын-Ул	57	10	5	5	5	25	0	0	0	3	1	
Эрдэнэдалай сум	1-р баг, Цавчир	51	10	5	5	5	25	0	0	1	5	0	
	2-р баг, Өнгөт	53	10	5	5	4.7	24.7	0	0	1	17	0	
	3-р баг, Тэнгэлэг	55	10	5	5	4.8	24.8	0	0	0	10	3	
	4-р баг, Рашаант	57	10	5	4.5	4.8	24.3	0	0	2	14	1	
	5-р баг, Цагаан-Ов	59	10	5	5	5	25	0	0	0	3	0	
	6-р баг, Сангийн д	61	10	5	5	4.9	24.9	0	0	0	7	1	
	7-р баг, Сумын төв	63	10	5	5	4.7	24.7	0	0	0	18	1	

Аймгийн ЗДТГ-аас санаачлан зохион байгуулсан Түмэнд ойрхон- Төрийн үйлчилгээ аяны хүрээнд 2018 оны 3-р сард Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад хэлтсийн дарга, мэргэжилтэнүүд ажиллаж тухайн сумдын өрхийн мэдээллийн санд газар дээр нь хяналт хийж ажиллахаас гадна үйлчлүүлэхээр ирж буй иргэдийн өрх хүн амын үзүүлэлтүүд үнэн зөв орсон мэдээллийг шинэчилсэн эсэхийг тодруулан иргэдэд мэдээлэл өгч ажилласан

Мөн овог нэр өөрчлөгдсөн хэдий ч мэдээллийн санд өөрчлөгдөөгүй байгаа хүмүүсийн судалгааг багуудаас авч эхний ээлжинд 5 хүний мэдээллийг засварлуулахаар МТГазарт хүргүүллээ.

Хүн ам өрхийн мэдээллийн санд овог нэр яаралтай солиулах шаардлагатай хүмүүс


Овог	Хуучин/ХАӨМС-д байгаа/			ЗӨВ /гэрчилгээн дээрх/			Хаяг	Тайлбар
	Нэр	Рдугаар	Овог	Нэр	Рдугаар			
1	Отгонцэцэг	Доржсамбуу	зе10210816	Адъяадорж	Доржсамбуу	зе10210816	Ду. Сайнцагаан 6-р баг	Овог солигдсон
2	Отгонцэцэг	Ёндонсамбуу	зе12290319	Адъяадорж	Ёндонсамбуу	зе12290319	Ду. Сайнцагаан 6-р баг	Овог солигдсон
3	Жаргалсайхан	Маралмаа	зю12260501	Жаргалсайхан	Мэндсайхан	зю12260501	Ду. Сайнцагаан 1-р баг	Нэр өөрчлөгдсөн
4	Өлзийочир	Бадамцэцэг	зю99010445	Өлзийочир	Бадамгарав	зю99010445	Ду. Сайнцагаан 2-р баг	Нэр өөрчлөгдсөн
5	Шинэжаргал	Тэмүүлэн	ЗЮ11261301	Бат-эрдэнэ	Тэмүүлэн	ЗЮ11261301	Ду. Сайнцагаан 7-р баг	Овог солигдсон

5. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)


2018 оны 2-р улирлын байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 977 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд байна. Үүнийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл үйл ажиллагаа явуулж байгаа 652, үйл ажиллагаа нь эхлээгүй 145, үйл ажиллагаагаа түр зогсоосон 145 үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон 28, бусад шалтгаантай 2 байгууллага байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 66,7 хувь буюу 652 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ,
хариуцлагын хэлбэрээр, 2018 оны 1-р
улирлын байдлаар



Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ,
үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, 2018 оны
1-р улирлын байдлаар



Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг сумдаар нь авч үзвэл Сайнцагаан суманд 332 буюу 50,9 хувь, Эрдэнэдалай суманд 37 буюу 5,7 хувь нь ногдож байна. Цагаандэлгэр, Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Луус суманд хамгийн бага буюу 14-18 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Энэ оны эхний улирлын байдлаар сонгогдон ирсэн 14 шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжээс шинэчлэн батлагдсан БР-1 маягтаар аж ахуйн үйл ажиллагааны тухай мэдээллийг тодруулан авч програмд оруулан санг баяжууллаа.

2018 оны 6 сарын 11-ний өдөр ҮСХ-ны Бизнес регистрийн албанаас зохион байгуулсан “Бизнес регистрийн сангийн сайжруулалт, програм хангамж ашиглалт” онлайн сургалтанд

Бизнес регистрийн сан хариуцсан мэргэжилтэн болон бусад мэргэжилтэнүүд бүрэн хамрагдлаа.

II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖИЛ

6. МАЛ ТООЛЛОГО (Ш6)

ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 05 сарын 23-ны өдрийн 01/428 тоот албан бичгийг үндэслэн аймгийн хэмжээнд хагас жилийн мал тооллогын ажлыг 6 сарын 4 ноос 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Мөн хэлтсийн даргын 2018 оны 05 сарын 29-ны өдрийн 32 тоот албан бичгийг бүх сумдад хүргүүлж мал тооллогын бэлтгэл ажлыг хангаж, бүх сумдад тооллогод ажиллах тоологч нарын сургалтыг сумандаа зохион байгуулж, маршрут төлөвлөгөө гарган ажиллалаа.

2018 оны 6 сарын 4-ны өдөр Хэлтсийн дарга Б.Энхтуяа, мэргэжилтэн Н.Түвшинжаргал нар 15 сумын багийн дарга нарт хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг чанартай зохион байгуулах, талаар сургалт, мэдээлэл өглөө.

Аймгийн хэмжээнд 15 сумын 66 багийн 1336 өрх сонгогдож 90 тоологч, 30 жолооч нийт 120 хүн ажиллаа.



Мал тооллогын хяналтаар Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Адаацаг сумдад хэлтсийн Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн, мэргэжилтэн Н.Түвшинжаргал, Г.Ариунжаргал нар 2 хэсэг гарч ажиллалаа. Тус хяналтаар 4 сумын 42 өрхөөр орж мал тооллогын маягт, мал тооллогод хамрагдсан өрхүүдээр орж мал тус бүрийг нүд үзэн тоолж сумын мал тооллогын комиссын тоолсон малтай нэг бүрчлэн тулгаж хяналт хийлээ.



7. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАГИЙН СУДАЛГАА /Ш-7/

2018 онд Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны багийн ахлагч, судлаачдад зориулсан сургалт 1 дүгээр сарын 8-12-ны хооронд болж ахлагч судлаач нар бүрэн хамрагдлаа.

Сургалтаар анхан шатны мэдээлэл цуглуулдаг судлаач нар, түүнийг хянаж шалгаж байдаг багийн ахлагч нарт ӨНЭЗС, АХС-ны асуулгыг зааврын дагуу үнэн, зөв, бүрэн, чанартай нөхөх чадвар эзэмшүүлэх, тэднийг нэгдсэн нэг ойлголттой болгох, судалгааны ярилцлага авах чадварыг дээшлүүлэх, асуулгын үзүүлэлт бүрийг нягт ойлгож, зөв нөхөх чадвартай байх зэрэг олон талын мэдлэг, мэдээлэл өглөө.

Сургалтын нээлтийн үеэр Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа “Статистикийн мэдээллийн үнэн, зөв, чанартай мэдээлэл гаргахад анхан шатны мэдээлэл цуглуулдаг судлаачид чухал үүрэгтэй. Өнгөрсөн онд бид “Ядуурлын дүр төрх-2016” судалгааны үр дүнг танилцуулсан. Тэгэхдээ анх удаа аймгийн түвшинд тооцож гаргасан. Энэ онд явуулах дэлгэрэнгүй судалгааны дүнгээр ядуурлыг аймгийн хэмжээнд тооцоолж “Ядуурлын дүр төрх -2018” судалгааны үр дүнг 2019 онд тархаах гэж байгааг онцлон танилцууллаа.



2018 онд ҮСХ-ноос баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу ӨНЭЗСудалгааны түүврийн нэгжийг ҮСХ-ноос авч, судалгаанд сонгогдсон өрхөөр биечлэн очиж /сард хөдөөгийн болон сумын төвийн өрхөд 1 удаа, аймгийн төвийн өрхөд дунджаар 4-7 удаа/ судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж, өрхийн хүнсний хэрэглээний дэвтэрүүдээ тарааж, судалгааг тогтсон аргачлал, зааврын дагуу таблетаар авч, мэдээллийг бүрэн цуглуулж байна.

Мэдээлэл цуглуулсанахаа дараа судалгааны асуулгыг үзүүлэлт бүрээр нь нэг бүрчлэн шалгаж нягтлан, хоорондын уялдаа холбоо, орлого зарлагыг тооцож ажил

мэргэжлээр нь кодолж, алдаагүй үнэн зөв мэдээллийг графикт хугацаанд нь ҮСХ-д дамжуулж байна. Энэхүү дамжуулсан мэдээг ахлагч татан авч, нэг бүрчлэн шалгаж ҮСХ-нд 100 хувь дамжуулдаг.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 312 өрх хамрагдсан. Үүнээс судалгааны явцад үндсэн өрх-290, нөөц өрх-22 хамрагдлаа.

Аймгийн төв болон хөдөөгийн сонгогдсон өрхүүдийн зарим нь хаягандаа байхгүй өөр аймаг суманд шилжин суурьших, түр хугацаагаар ажиллах, цаг агаарын байдлаас шалтгаалан отроор нүүх, ахмад настай хөгшчүүд өөр аймаг сум, хотод болон гадаадад хүүхдүүд дээрээ очиж өвөлжих, хүүхдийг нь харах, гэр бүлийн хүнээ эмчлүүлэхээр түр хугацаагаар эзгүй явах зэргээс болж нөөц өрх судалгаанд хамрагдаж байна. Тухайн сонгогдсон өрхийн мэдээлэл ХАӨМС-н программ дахь мэдээлэлтэй зөрүүтэй байсан тохиолдолд багийн даргад хандаж засуулж хэвшсэн.

Мөн өрх тус бүрт урамшууллын мөнгийг тарааж гарын үсэг зуруулж баталгаажуулж хэвшсэн.

Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгаанд хамрагдсан өрхүүдийн өдрийн тэмдэглэлийн хөтөлгөөг сар бүр архивлан хадгалж байна.



8.АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА /Ш-8/

ҮСХ-ны даргын 2017 оны 12 р сарын 18 ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан мэдээ, тайлангийн графикийн дагуу АХС-ны мэдээг сар болгоны 25-нд судлаач нар дамжуулж, ахлагч мэдээг нэг бүрчлэн хянаж, алдаа гарвал засуулж дараа сарын 1-нд ҮСХ-нд хугацаанд нь 100 хувь дамжуулж байна.

АХС-ны жагсаалтыг сонгогдсон багуудаас сар бүрийн 20 нд авч нэгтгэн, ҮСХ-д 25 ны дотор дамжуулдаг. Бидний явуулсан жагсаалтаас судалгаанд сонгогдсон өрхүүдийн нэр ирж, уг өрхүүдээс сар бүр судалгааг авч байна. Судалгаанд сонгогдсон өрхөд биечлэн очиж судалгааныхаа зорилго, ач холбогдлыг танилцуулж өрх тус бүрт урамшууллын мөнгийг бүрэн өгч гарын үсэг зуруулж баталгаажуулж хэвшсэн.

Судалгааг тогтсон аргачлалын дагуу таблетаар бүрэн гүйцэд авч байна. Мэдээлэл цуглуулсаны дараа судалгааны асуулгыг үзүүлэлт бүрээр нэг бүрчлэн шалгаж нягтлан,

хоорондын уялдаа холбоо, орлогыг тооцож ажил мэргэжлээр нь кодож, хугацаанд нь дамжуулж байв.

2018 оны эхний хагас жилийн байдлаар АХС-нд нийт 240 өрх сонгогдсоны 233 нь үндсэн өрх, 7 нь нөөц өрх судалгаанд хамрагдлаа.

Багийн дарга нар нэрсийн жагсаалтаа өгөхдөө шилжсэн, нас барсан, түр хугацаагаар болон удаан хугацаагаар эзгүй байгаа, отроор нүүж яваа өрхүүдээ тайлбарт тусгайлан тодруулж өгч байгаа боловч тус аймгийн иргэд Улаанбаатар хот Өмнөговь аймаг зэрэг үйлдвэр, уурхай ихтэй суурин газарт түр хугацаагаар явах нь элбэг байгаа зэргээс шалтгаалж нөөц өрх сонгогдож байна.

Сонгогдсон өрхүүдийг байрлалаар нь авч үзвэл аймгийн төвийн 84 өрх, сумдын 156 өрх хамрагдсан байна.

Мөн энэ оны 2 р улирлаас эхлэн ажиллах хүчний судалгааны асуулга шинэчлэх туршилтын судалгаа сар бүр явагдаж байна.

Хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунжаргал уг судалгааг авах ажилтнаар сургалтанд сууж мэргэшиж ирсэн бөгөөд сар бүр 3 нэгжийн 36 өрхөөс аргачлал зааврын дагуу судалгааг таблетаар бүрэн авч, шалган дамжуулж байна. Энэ улиралд 96 өрхөөс мэдээллийг авч дамжуулсан болно.

9.ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА /Ш-9/

Нэг.ОЛОН УЛСЫН ӨРТГИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА

Олонулсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн судалгааг тус хэлтсийн үнэ хариуцсан мэргэжилтэн Г.Ариунжаргал хийсэн бөгөөд 2018 оны 5 сарын 31-нд судалгаа дууссан юм. 2018 онд сар бүр хүнс, архи гэсэн 2 бүлгийн 110 нэрийн бүтээгдэхүүний үнийг худалдааны 3 цэгээр орж судлан програмд шивж Үндэсний Статистикийн хороонд дамжууллаа. Мөн 2 болон 5 сард бүх бүлгийн буюу 450 нэрийн бүтээгдэхүүний үнийг судлан програмд шивэн ҮСХ-д хугацаанд нь дамжууллаа.



Хоёр.АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (ТУРШИЛТ 2018)

2018 онд хийгдэж буй Ажиллах хүчний судалгааны асуулгыг шинэчлэх зорилготой энэхүү туршилт судалгааны сургалтад 2018 оны 3 дугаар сарын 15-18ны өдрүүдэд тус хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунжаргал хамрагдан судалгааг сонгогдсон өрхүүдээс авч програмд

шивэн ҮСХ-д дамжуулж ажиллалаа. Тус судалгаа нь энэ оны 2,3 дугаар улиралд хийгдэх юм.



Судалгаанд үндсэн АХС-тай хамт нэгжүүд сонгогдох бөгөөд өрх нь өөр нийт 15 нэгжийн 150 өрхөөс судалгаа авахаас одоогоор 4 дүгээр сард Адаацаг сумын Тавин баг, Луус сумын Суврага баг, Сайнцагаан сумын Далай баг, 5 дугаар сард Өндөршил сумы Талын нар баг, Говь-Угтаал сумын Морьт баг, Сайнцагаан сумын Боржигон баг нийт 6 нэгжийн 60 өрхөөс судалгааг аваад байна.

III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

10. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)

10.1 СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10.1)

2018 онд зохион байгуулах сургалт семинарын нэгдсэн графикийг хэлтсийн даргаар батлуулан, графикийн дагуу сургалтыг зохион байгуулаад байна. Мөн сургалт зохион байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор тухайн сургалтын тайланг ҮСХ-д илгээж ажилласан.

БАТЛАВ
ДУЧИГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Б.ЭНХТУЯА*

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

А Хэлтсийн хэрэглэгчид бусад хамтран ажиллахад оюутан суралчдад зориулсан сургалт

№	Сургалтын нэр	Сэдэв	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамрагдах хүн
1.	БХСС, Сайнцагаан Хулд Луус Өгэнийт	Анхан шатны бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах ХАӨМГ, МАА, судалгаа	1-р улирал	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	Сумдын ААНБ-ын нөбө нар, ТСМ, БЗД
2.	БХСС- Говь-Угтаал Цагаандолгор Дэлгэрцогт	Анхан шатны бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах ХАӨМГ, МАА, судалгаа	2-р улирал	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	Сумдын ААНБ-ын нөбө нар, ТСМ, БЗД
3.	ИИС-МСУТ сургалт	Статистикийн тухай ойлголт, мэдээ мэдээллийн ач холбогдол	3-р улирал	Н.Түвшинкаргал	МСУТ оюутнууд
4.	БХСС- Дэлгэрхангай Сайхан-овоо Эрдэнэдалай	Анхан шатны бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах ХАӨМГ, МАА, судалгаа	3-р улирал	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	Сумдын ААНБ-ын нөбө нар, ТСМ, БЗД
5.	ИЕС- ЕБС сургалт	Статистикийн тухай ойлголт, мэдээ мэдээллийн ач холбогдол	4-р улирал	Т.Бямбасүрэн	ЕБС суралчид

Б Ажлын байрны сургалт дотоод

№	Сэдэв	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамрагдах хүн
1	Цаг үеийн шаардлагатай асуудлаар сургалт хийх, шинэ ажиллыг сургах	Улирал бүр	Б. Энхтуяа	Хэлтсийн ажилчид
2	Монгол хэл бичиг, онцгой болон бусад байгууллагаас зохион байгуулж буй сургалт	1-р улирал	С.Доржзанд	Хэлтсийн ажилчид
3	Компанийн хэрэглээг сайжруулах, шинэийн болон бусад байгууллагаас зохион байгуулж буй сургалт	2-р улирал	Н.Түвшинкаргал	Хэлтсийн ажилчид
4	Ажил хэл, оюутан болон бусад байгууллагаас зохион байгуулж буй сургалт	3-р улирал	Т.Бямбасүрэн	Хэлтсийн ажилчид
5	Хууль зох зүй, архив, албан хэрэг хөтлөлт, онцгой болон бусад байгууллагаас зохион байгуулж буй сургалт	4-р улирал	Г.Ариунжаргал	Хэлтсийн ажилчид

В Ажлын байрны сургалт гадаад

№	Сэдэв	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамрагдах хүн
1	ҮСХ болон бусад байгууллагад сурч мэдлэг, чадвараа дэвшүүлэх	Улирал бүр	Б. Энхтуяа	Хэлтсийн ажилчид
2	Өмнөд сургалтын судалгааны сургалт	1-р улирал	Б.Энхтуяа	Ахлах, судлаач нар
3	SPSS, E-Views програмын сургалт	1-р улирал	Т.Бямбасүрэн	Хэлтсийн ажилчид
4	MS-Excel-статистикийн функц, Access програмын сургалт	2-р улирал	С.Доржзанд	Хэлтсийн ажилчид
5	"Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд ойлгомжтой байдалд оруулах" сэдэвт програмын сургалт	3-р улирал	Н.Түвшинкаргал	Хэлтсийн ажилчид
6	Архив, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт	4-р улирал	Г.Ариунжаргал	Хэлтсийн ажилчид

Жич: Г.Гаданд сургалтанд хамрагдсан ажилтан хэлтсийн ажилчдад сургалт зохион байгуулж тайлагнаана.

Төлөвлөгөө боловсруулсан:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Б.Энхтуяа* / Л.БЯМБАСҮРЭН

1.БХСС-Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудад буюу аймаг, сум, баг хорооны статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт

Нэг.Хэлтсийн даргын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу 2018 оны 3 сарын 14-16-ны хооронд хэлтсийн дарга Б. Энхтуяа , ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн, мэргэжилтэн

Н.Түвшинжаргал нар Луус, Хулд сумдад сургалт мэдээлэлхяналт үнэлгээ хийн ажиллалаа. Мөн 3 сарын 22-нд Сайнцагаан суманд хэлтсийн дарга Б.Энхтуяа, ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн, мэргэжилтэн Н.Түвшинжаргал, С. Доржханд нар сумын статистик хариуцсан төрийн сангийн мэргэжилтэн, багийн засаг дарга нар, багуудын нийгмийн ажилчид болон сумын бусад ажилтнуудыг хамруулан сургалт мэдээлэл хийж ажиллалаа.

Сургалт хөтөлбөрийн дагуу амжилттай явагдаж сумдын статистик хариуцсан мэргэжилтэн, багийн засаг дарга нар, сумын удирдлагууд, аж ахуй нэгжийн эзэд нягтлан бодогч нарт хэлтсийн танилцуулга, хууль эрх зүй, аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга, ХАӨМС, Мал тооллогын мэдээллийн сангийн шинэчлэлт хэрэглээ, Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ийг дэлгэрэнгүй танилцуулж 1212.mn-ийг сурталчилсан юм.

Сургалт мэдээлэлд оролцсон иргэд талархалтай хандаж буйгаа илэрхийлсэн хүсэлтээ санал хүсэлтийн хуудаснаа бичиж үлдээсэн байна.

Луус болон Хулд сумдын Сургалтанд Статистик хариуцсан мэргэжилтэнүүд багийн засаг дарга нараас гадна тус сумын удирдлагууд ААН-ийн эзэн нягтлан бодогч нар хамрагдсан юм.

Сумын статистик хариуцсан мэргэжилтэн, багийн дарга нарын сургалтын явцад ХАӨМС, мал тооллого ХАА-н программын талаар лавлаж асууж хүснэгт хэрхэн үүсгэх зэрэг үйлдлүүдийг заалгаж авсан бөгөөд Мал тооллогын мэдээлэл оруулдаг програм дээр үр дүнгийн хүснэгт үүсдэг болсонд талархалтай хандаж буйгаа илэрхийлж байлаа.





Мөн хяналт шалгалтын хүрээнд багийн дарга нарын хувьд багийн дарга нараас гардаг ХАА-1, ХАА-2 мэдээний анхан шатны хөтөлгөө бүртгэлүүд хангалттай, ХАӨМС-ийн баяжилт, алдаа засварлалт боломжийн байлаа. Мал тооллогын сангийн цахим шивэлт болон МТ-1 маягтын мэдээлэл зарим зүйл зөрсөн цөөн тохиолдлол гарсан бөгөөд тухай бүр засуулж ажилласан.

Сургалт мэдээллийн ирцийн бүртгэл 2018.03.22

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1	Б.Батбаяр	У.Д. ХТД	97527174	
2	М.Батбаяр	У.Д. ХТД	97527179	
3	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
4	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
5	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
6	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
7	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
8	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
9	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
10	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
11	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
12	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
13	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
14	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
15	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
16	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
17	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
18	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
19	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
20	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
21	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
22	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
23	С.Батбаяр	У.Д. ХТД	97527176	
24				
25				
26				
27				
28				
29				
30				
31				
32				
33				
34				
35				
36				
37				
38				
39				
40				
41				

Сургалт мэдээллийн ирлийн бүртгэл				2018.03.15
№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
2	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
3	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
4	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
5	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
6	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
7	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
8	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
9	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
10	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
11	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
12	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
13	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
14	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
15	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
16	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
17				
18				
19				
20				
21				
22				
23				
24				
25				
26				
27				
28				
29				
30				
31				
32				
33				
34				
35				
36				
37				
38				
39				
40				
41				

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс

Сургалт мэдээллийн ирлийн бүртгэл				2018.03.15
№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
2	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
3	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
4	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
5	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
6	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
7	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
8	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
9	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
10	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
11	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
12	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
13	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
14	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
15	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
16	М.Сүхбаатар	М.Сүхбаатар	99112117	М.Сүхбаатар
17				
18				
19				
20				
21				
22				
23				
24				
25				
26				
27				
28				
29				
30				
31				
32				
33				
34				
35				
36				
37				
38				
39				
40				
41				

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс

Хоёр.Статистикийн салбарын хариуцсан мэргэжилтнүүдэд өгсөн сургалт.
 Тус хэлтсээс 2018 оны 1 сарын 25нд сумдын Статистик хариуцсан мэргэжилтнүүдэд 2017 оны ажил дүгнэсэн байдлыг танилцуулж, 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд болон цаашид анхаарах зүйлүүдийн талаар Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд мэдээлэл хийлээ. 2018 онд сумдын анхан шатны мэдээний бүртгэл хөтлөлт, баримтжуулалт, Багийн засаг дарга нарын чадавхийг сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч ажиллах талаар салбар бүрийн мэргэжилтнүүд мэдээлэл өгсөн юм.



Сургалтанд тус аймгийн 15 сумын статистик хариуцсан төрийн сангийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдлаа.

2. ААНС- Статистикийн анхдагч мэдээллийг бүрдүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт.


Нэг.Тус хэлтсийн 2018 оны сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг 2018 оны 4 сарын 8-9ний өдрүүдэд Сайхан-овоо, Эрдэнэдалай суманд зохион байгууллаа.Уг сургалтын зорилго нь статистикийн тухай хууль, холбогдох заавар журмын хэрэгжилт, мэдээний үнэн бодит байдал, хамралтыг дээшлүүлэх хүрээнд орон нутгийн анхан шатны нэгжид биечлэн туслах, ажлын заавар зөвлөгөө өгөх байлаа.

Сумдын нийт төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын нягтлан бодогч нарыг цуглуулан сургалтыг статистикийн хэлтсийн дарга Б.Энхтуяа Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль,мэдээ тайлан гаргахад анхаарах асуудал, мэдээ тайланг санаатайгаар хожимдуулах, алдаа гаргах зэрэгт тооцох хариуцлага, хуулийн заалтууд, цаг үеийн холбогдолтой бусад мэдээ мэдээлэл, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn болон түүний хэрэглээ сэдвүүдээр сургалт хийлээ. Мөн хэлтсийн үйл ажиллагааны танилцуулга, 2017 оны жилийн эцсийн танилцуулга сургалтын хөтөлбөрт багтсан юм. Сургалтанд Сайхан-Овоо сумын 11 нягтлан, Эрдэнэдалай сумын 21 нягтлан нийт 32 хүнийг харуулсан юм.



Сургалтанд хэлтсийн 2017 оны жилийн эцсийн танилцуулга 32 ширхэгийг тарааж сургалтан оролцсон бүх хүмүүсээс санал асуулга авлаа.





2018.04.08

Цэргийн бүртгэл

1. В. Вилертин	АНБ-ын	нарын үеэр
2. С. Ардгалмаа	Сүх Баян Гангай ХХК	Б. Доржпэл
3. С. Моголдор	Авгайн Арван Арванхоёр - ХХК	Б. Доржпэл
4. С. Доржпэл	Товч ХХК	Б. Доржпэл
5. Д. Салхуу	Моголдор	Б. Доржпэл
6. Д. Доржпэл	Дорнод-Сүхбаатар	Б. Доржпэл
7. А. Ноголдор	Авгайн Арван Арванхоёр ХХК	Б. Доржпэл
8. " "	Авгайн Арван Арванхоёр ХХК	Б. Доржпэл
9. " "	Авгайн Арван Арванхоёр ХХК	Б. Доржпэл
10. Г. Шандор	Товч ХХК	Б. Доржпэл
11. Ноголдор	Дорнод-Сүхбаатар ХХК	Б. Доржпэл
12. " "	Авгайн Арван Арванхоёр ХХК	Б. Доржпэл
13. С. Моголдор	Сүх Баян Гангай ХХК	Б. Доржпэл
14. В. Моголдор	Дорнод-Сүхбаатар ХХК	Б. Доржпэл
15. Авгайн Арван Арванхоёр	Авгайн Арван Арванхоёр ХХК	Б. Доржпэл
16. Д. Доржпэл	Товч ХХК	Б. Доржпэл
17. Д. Вилертин	Моголдор, Авгайн Арван Арванхоёр	Б. Доржпэл
18. Д. Вилертин	Дорнод-Сүхбаатар ХХК	Б. Доржпэл
19. М. Цогин	Сүх Баян Гангай ХХК	Б. Доржпэл
20. М. Цогин	Сүх Баян Гангай ХХК	Б. Доржпэл
21. М. Цогин	Сүх Баян Гангай ХХК	Б. Доржпэл

2018.04.08

Цэргийн бүртгэл

1. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
2. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
3. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
4. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
5. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
6. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
7. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
8. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
9. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
10. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
11. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
12. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
13. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
14. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
15. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
16. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
17. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
18. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
19. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
20. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр
21. ААН Б-ын	Орлогын	нарын үеэр

4. Дотоод сургалт

Нэг.ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН САХИЛГА, ХАРИУЦЛАГА НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс санаачилан төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилготой зөвлөгөөнд тус хэлтсийн 3 албан хаагч хамрагдсан байна. Хэлтсийн дарга Б.Энхтуяа, хүн ам хариуцсан мэргэжилтэн С.Доржханд нар удирдах ажилтнуудын салбар сургалт, мэргэжилтэн Г.Ариунжаргал архив албан хэрэг хөтлөлтийн салбар сургалтуудад тус тус хамрагдсан юм.Зөвлөгөөнд сум, хэлтэс, агентлагийн 350 орчим төрийн албан хаагчид оролцлоо.



Хоёр.СТАТИСТИКИЙН ОРОН НУТГИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН SPSS, EIEWSСТАТИСТИКИЙН ПРОГРАМЫН СУРГАЛТ

Үндэсний статистикийн хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Статистикийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн ажилтнуудад зориулсан SPSS, EViews статистикийн програмын сургалтанд Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн 2018 оны 3 сарын 26-31 -ний өдрүүдэд амжилттай оролцлоо.

Сургалтад нийт 21 аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэнүүд мөн нийслэлийг төлөөлж Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2 мэргэжилтэн оролцсон бөгөөд сургалтыг нээж ҮСХ-ны дарга А.Ариунзаяа нээж үг хэлж сургалтанд оролцогчидод амжилт хүссэн юм.

Сургалт хөтөлбөрийнхөө дагуу амжилттай явагдсан бөгөөд анхан шатнаас нь заах явцдаа дасгал ажиллах хэлбэрээр явсан нь илүү үр дүнтэй болсон гэж дүгнэж байна.



Гурав.АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ АСУУЛГА ШИНЭЧЛЭХ ТУРШИЛТЫН СУДАЛГАА"-НЫ СУРГАЛТ. Үндэсний Статистикийн Хорооноос зохион байгуулсан "Ажиллах хүчний судалгааны асуулга шинэчлэх 2018 оны туршилтын судалгаа" ны сургалтанд хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунжаргал 2018 оны 4 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд амжилттай оролцлоо. Уг сургалтын зорилго нь:

- Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэх ажлын хүрээнд ОУХБ-аас зөвлөмж болгож буй асуулгыг турших, мэдээлэл цуглуулах;
- Аргачлал шинэчилснээр гарах тоон үзүүлэлтийн өөрчлөлтийн хандлагыг харах, хөдөлмөрийн статистикийн олон улсын стандартыг үндэсний онцлогтой уялдуулах;
- Хөдөлмөрийн статистикийн аргачлал, мэдээллийн маягыг шинэчлэн боловсруулах.

Сургалтад нийт 21 аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэнгүүд мөн нийслэлийн хувьд судлаач нар оролцсон бөгөөд сургалтыг нээж ҮСХ-ны ХАНСГ-ын дарга А.Амарбал нээж үг хэлж сургалтанд оролцогчидод амжилт хүссэн юм.

Сургалтыг ҮСХ-ны ХАНСГ-н ахлах статистикч Э.Гантуяа, ҮСХ-ны ХАНСГ-н шинжээч Б.Уламбадрах, ҮСХ-ны ХАНСГ-н шинжээч Т.Энхжин нар зохион байгууллаа.

Нийт судлаач нартаа түс бүрт нь судалгаанд ашиглах таблет тараасан бөгөөд үүнийг ариг гамтай ашиглах талаар үүрэг сануулга өгч хэрхэн асуулга авах маягтаа хэрхэн бөглөх талаар үнэтэй сургалт зөвлөгөө өглөө.



Дөрөв.ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНООС ЗОХИОН БАЙГУУЛСАН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭР ИНФОГРАФИКЫН СУРГАЛТ.

ҮСХ-оос зохион байгуулсан инфографик хийх 5 хоногийн сургалтанд хэлтсийн мэргэжилтэн Н.Түвшинжаргал оролцоод ирлээ. Уг сургалтанд ҮСХороо болон 21 аймаг, нийслэл, дүүрэг, яамдын 40 гаруй мэргэжилтэн хамрагдаж амжилттай төгслөө.



Сургалтаар Adobe Illustrator программын сургалтыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн хэвлэлийн график-дизайны багш Б.Баянжаргал, Adobe photoshop программын сургалтыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн хэвлэлийн технологийн багш Б.Цолмон нар удирдан явууллаа.

Сургалтын дадлага ажлын хүрээнд дундговь аймгийн 2017 оны хүн амын насчилсан инфографик, хүүхдийн баярыг тохиолдуулан 0-18 насны хүүхдийн инфографикуудыг хийлээ.

Тав.ӨРХИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ СУРГАЛТ

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны сургалт 2018 оны 1-р сарын 08-наас 11-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болж аймгаас ахлагч, 3 судлаач нарын хамт бүрэн хамрагдлаа.

Энэхүү сургалтыг ҮСХ-ны дарга А.Ариунзаяа нээж, сургалтын зорилго, судлаач нарын үүрэг, хариуцлагын талаар танилцуулж, сургалтандаа идэвхитэй оролцохыг уриаллаа.Тус сургалт 4 өдөр үргэлжилсэн бөгөөд ӨНЭЗ-ийн судалгааны зорилго, ач холбогдол, онцлог, үр дүн, ӨНЭЗС-ны асуулгын бүрэлдэхүүн, бүтэц, асуулга нөхөх зөвлөмж, бусад орлогын талаар ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч С.Болормаа, ӨНЭЗС-ны түүвэрлэлт, өрхийн ерөнхий асуулга, өрхийн ам бүлийн байдал, өрх, түүнд бүртгэгдэх хүнийг тодорхойлох талаар ХАНСГ-ын ахлах шинжээч Д.Даваажаргал, Боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлтийн талаар ахлах шинжээч Н.Хэнбиш, шинжээч Э.Мягмарханд, ХАА н үйлдвэрлэл, хэрэглээ, хоол тэжээлийн хөтөлбөрийн үнэлгээний талаар Д.Даваажаргал, ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, өрхийн өдрийн тэмдэглэл, өрхийн хүнсний зүйлийн хэрэглээний талаар Э.Мягмарханд, Хадгаламж зээл, орон сууц эрчим хүчний талаар С.Болормаа, Удаан эдэлгээт бараа, эд хогшлын талаар Н.Хэнбиш нар хичээл заав.

АХС-ны түүвэрлэлт, хамрах хүрээ, Өрхийн шинэчилсэн жагсаалт ирүүлэх арга зүй баримтлах зарчим, нэмэлт ажил хийх боломж, ажилгүй иргэн, эдийн засгийн идэвхи, Ажил мэргэжлийн ангилал, Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалын талаар ХАНСГ-ын шинжээч Б.Уламбадрах, Судалгааны асуулгын бүтэц, ярилцлага авах зөвлөмж, Эдийн засгийн тухайн үеийн идэвхи, Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, Өрхийн гишүүдийн цалин хөлсгүй ажил үйылчилгээний талаар ҮСХ-ны ХАНСГ-ын шинжээч Д.Анхзаяа нар хичээл заалаа.


Мөн тус сургалтанд оролцогчдоос шалгалт авч, судалгааны мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээлийн талаар харилцан ярилцлаа. Мөн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, сайн туршлагын талаар зарим аймгийн дарга нар мэдээлэл хийж, туршлага солилцлоо..

Ш.10.2СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10.2)

1. ХБХ- Хэвлэлийн бага хурал

Статистикийн хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон сурталчилгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сар бүрийн12 нд багтаан

Аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулгын товч мэдээллээр ЗДТГ-н дэргэдэх АРД телевиз, Дундговийн амьдрал сонинд тогтмол хэвлэлийн хурал хийж ажиллалаа. 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийтдээ будаа сарын танилцуулгаар хэвлэлийн хурлыг хийсэн бөгөөд тухай бүр тайланг ҮСХ-д хүргүүлж байлаа.


 БАТЛАВ
 ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА *С.ДОРЖХАНД*
 Б.ЭНХТУЯА
 СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ
 СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн сарын хэвлэлийн хурал болон АС цогцолборын мэдээ	Хариуцах ажилтан	Тооллого судалгааны сурталчилгаа	Хариуцах ажилтан
1-р сар	С.Доржханд		
2-р сар	Н.Түвшинжаргал Г.Баясгалан	2017 оны ХАА-н танилцуулгаар мэдээлэл хийх	Н.Түвшинжаргал
3-р сар	Г.Ариунжаргал Б.Энхтуяа		Г.Ариунжаргал Т.Бямбасүрэн
4-р сар	Д.Чогсомжав	2017 оны Ажиллах хүчний судалгааны үр дүн	Г.Ариунжаргал Т.Бямбасүрэн
5-р сар	Т.Бямбасүрэн Г.Болормаа	2017 оны Хүн амын танилцуулгаар мэдээлэл хийх	С.Доржханд
6-р сар	С.Доржханд Б.Энхтуяа	2017 оны Ажил эрхлэлтийн танилцуулгаар мэдээлэл хийх	Г.Ариунжаргал
7-р сар	Н.Түвшинжаргал	2017 оны АУ-рийн танилцуулгаар мэдээлэл хийх	Т.Бямбасүрэн
8-р сар	Г.Ариунжаргал Ж.Мөнхбаяр		Б.Энхтуяа
9-р сар	Д.Чогсомжав Б.Энхтуяа	Нийгмийн уулуултийн түүвэр судалгаа	Д.Чогсомжав
10-р сар	Т.Бямбасүрэн		
11-р сар	С.Доржханд Г.Баясгалан	Тооллогын сурталчилгаа	Б.Энхтуяа С.Доржханд Н.Түвшинжаргал
12-р сар	Т.Бямбасүрэн Б.Энхтуяа		

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *М.Бадарж* /Т.БЯМБАСҮРЭН/

Сар бүрийн хэвлэлийн хуралтай хамтатган хэлтсийн цаг үеийн мэдээ мэдээлэл, www.1212.mn-Статистик мэдээллийн нэгдсэн сан болон 1212.mn апплэкэйшний сурталчилгааг хийж байна.

Хэлтсээс жил бүр эрхлэн гаргадаг Хөдөө аж ахуйн танилцуулгыг 2018 оны 03 сарын 30 өдөр гаргаж хэвлэмэл байдлаар 20 ширхэгийг хэвлэн аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нарт тархаалаа. Мөн 15 сумын засаг дарга, сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд, Багийн засаг дарга нарт цахимаар хүргүүллээ. Мөн аймгийн “Ард телевиз”, вэб хуудас, фэйсбүүк, Дундговь аймгийн байгууллагын цогц мэдээлэл /и-оффисс/ зэргээр олон нийтэд тархаасан.

ХАА-н танилцуулга тархаасан жагсаалт

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	2018.03.30 Гарын үсэг
1	Сүхбаатар	МАНДУУХТЭН	9611288	<i>[Signature]</i>
2	Сүхбаатар	МАНДУУХТЭН	8808000	<i>[Signature]</i>
3	Сүхбаатар	МАНДУУХТЭН	9959965	<i>[Signature]</i>
4	Сүхбаатар	МАНДУУХТЭН	99548337	<i>[Signature]</i>
5	Сүхбаатар	МАНДУУХТЭН	9909635	<i>[Signature]</i>
6	Сүхбаатар	МАНДУУХТЭН	8804888	<i>[Signature]</i>
7	ХАА-н дарга	ХАА-н дарга		<i>[Signature]</i>
8	Сүхбаатар	МАНДУУХТЭН		<i>[Signature]</i>
9	Сүхбаатар	МАНДУУХТЭН	88788746	<i>[Signature]</i>
10	Сүхбаатар	МАНДУУХТЭН	8877773	<i>[Signature]</i>
11				
12				
13				
14				



Хэлтсийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хэрэглэгчдэд зайлшгүй тархах 4 судалгааны нэг болох 2017 оны Хүн ам, өрхийн танилцуулгыг хэлтсийн хүн ам хариуцсан мэргэжилтэн С.Доржханд 2018 оны 4 сарын 30 өдөр гарган dundgovi.nso.mn вэб хуудсанд байршууллаа.

ДУНДГОВЬ
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Хүн амын тоо, түүний өсөлт 2017 оны жилийн эцсийн мэдээгээр аймгийн хүн амын тоо 46363 болж өмнөх оноос 968 хүнээр буюу 1,85 хувиар өссөн нь Монгол улсын хүн амын 15 хувийг эзэлж байна. Тус аймгийн хувьд 15 сумын 13 суманд хүн амын тоо 0,3-3,7 хувиар өсч, 2 суманд буурсан байна. Нийт хүн амын 49,8 хувь буюу 23078 нь эмэгтэй, 50,2 хувь буюу 23305 нь эрэгтэйчүүд байна. Аймгийн нийт хүн амын өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 2012-2013 онд 0,5 хувиар, 2013-2014 онд 0,4 хувиар буурч байсан бол 2015-2017 онуудад 1,3-1,9 хувиар өссөн байна.

Мөн Аймгийн ЗДТГ-ын даргын батласан хуваарийн дагуу 5 сарын 2-ны өдөр 11 цаг 30 минутад онцгой байдлын газрын аюулаас сэргийлэх АС цогцолбороор хүн өрхийн танилцуулгаар 20 минутын мэдээлэл хийж хөдөөгийн малчдад мэдээллийг хүргэлээ. Мөн тухайн танилцуулгыг 8 хувь гарган Аймгийн Засаг дарга, харъяа хэлтэс агентлагууд, ИТХуралд хэвлэмэлээр тархаасан.

Зар мэдээ (449) | 1-25 | 2 | 3 | 4 | 5 | 1

Энөөдөр (1)

2017 оны хүн ам өрхийн танилцуулга
Статистикийн хэлтэсээс 2017 оны хүн ам өрхийн танилцуулгыг гаргалаа. Хавсралт файлаас шаардлагатай мэдээг

Өчигдөр (5)


АУДИТААС-ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРТ
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, аймгийн иргэдийг хаагчийн судалгаа, хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шүүх байгууллагаас гаргасан акттай холц нэгтгэлийг санхүүгийн албаны дарга нар нэгтгэж ирүүлээ үү.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР
Зөвлөгөөн маргааш буюу 05 дугаар сарын 13-нд ТХДЖТ-т 08:00 цагт эхэлнэ. Хөтөлбөрийг хавсаргав.

ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, ГАЗАР, СУМДЫН ДАРГА НАРТ
Монгол Улсын Засгийн газраас зарласан "Хариуцлагын жил"-ийн хүрээнд Дундговь аймагт хэрэгжүүлэх ажил, ари

Танилцуулгыг олон байгууллага, сумдад шуурхай хүртээмжтэй хүргэхийн тулд Дундговь аймгийн төрийн бүх байгууллага, 15 суманд төрийн бүх албан хаагчдын ашигладаг ABLE програмын олон нийтийн хэсэгт PDF хэлбэрээр байршууллаа. Ингэж байршуулсанаар Дундговь аймгийн төрийн 61 байгууллага 953 албан хаагчдад тухайн мэдээлэл нэгэн зэрэг хүрч өөрийн хүссэн тоо мэдээллийг excel болон PDF хэлбэрээр татаж хэрэглэх боломжтой юм.

Үүнээс гадна аймгийн ЗДТГ-аас гаргадаг хуваарийн дагуу сар бүр 2 удаа Онцгой байдлын газрын АС буюу аюулаас сэрэмжлүүлэх цогцолбороор иргэд, малчидад мэдээлэл хүргэж байна. АС цогцолборнь 2015 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба Дундговь аймгийн хэмжээнд бүх сумдад хүрдэг радио FM бөгөөд малчдадхамгийн ойр мэдээллийн хэрэгсэл юм. 2018 оны 1 сард багийн Засаг дарга нараас авсан судалгаагаар тухайн FM-г 15 сумын 1027 малчин өрх тогтмол сонсдог нь нийт малчин өрхийн 15 хувь байна.



ТСС-Тооллого судалгааны сурталчилгаа

Нэг.АХС-ны 2017 оны үр дүнгээр хийсэн сурталчилгааны ажил

2018 оны 3 сарын 20 нд Аймгийн ХХҮГ-аас Татварын хэлтэс, МСҮТ, ХХААГ, Статистикийн хэлтэстэй хамтран Ажилгүйдлийг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бодлого боловсруулагчдын хэрэгцээ шаадлагад нийцүүлэн зохион байгуулж буй Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны сургалтанд оролцсон бөгөөд Статистикийн хэлтсийн зүгээс 2017 оны Ажиллах хүчний судалгааны үр дүнг танилцуулж, судлаачдад анхаарах асуудлын талаар мэдээлэл өглөө. Мөн Аймаг орон нутгийн нийгэм эдийн засгийн байдлын үр дүн оновчтой, үнэн бодит мэдээлэлд суурилсан тоо мэдээллийг анхан шатны нэгжээс цуглуулахад сумдын удирдлагууд төрийн албан хаагчдын оролцоо, үүрэг хариуцлага ямар байдаг талаарх хууль эрхзүйн мэдээллийг танилцуулж, Статистикийн хэлтсийн өрхөд суурилсан ӨНЭЗС, АХС-ны зорилго, ач холбогдлын талаарх мэдээллийг өгч судалгаанд сонгогдсон тохиолдолд идэвхитэй оролцох, судлаач нарт тусалж дэмжин ажиллах тал дээр анхаарууллаа. Тус үйл ажиллагаанд нийт 60 хүн хамрагдсан.

ХХҮГ-аас зохион байгуулж буй энэхүү судалгаанд шаардлагатай мэдээлэл болох Малчин өрх, мал бүхий өрх, 200-аас доош малтай өрх зэрэг мэдээллийг гаргаж өгсөн төдийгүй цаашид ч шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахаа мэдэгдлээ.



Сургалтын үр дүн: Сумдын удирдлагууд болон төрийн албан хаагчид Статистикийн хэлтсийн анхан шатны мэдээ, судалгааны ач холбогдлыг ойлгож мэдээний чанар, бодит байдал сайжирна. Мөн Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг зөвхөн орон нутагт зохион

байгуулж байгаа учир судалгаа амжилттай сайн зохион байгуулагдсанаар аймаг, орон нутгийн ажил эрхлэлт сайжирч, ажилгүйдэл, ядуурал буурах ач холбогдолтой юм.

2. Хагас жилийн мал тэжээвэр амьтдын тооллого

Дундговь аймгийн Статистикийн хэлтсээс 2018 оны 06 сарын 06 нд 15 сумын 66 багийн Засаг дарга, нийгмийн бодлогын мэргэжилтэн нарт 2018 оны хагас жилийн мал тооллогыг хэрхэн явуулах тухай мэдээлэл өглөө. Мөн 2017 оны Хөдөө аж ахуйн танилцуулгыг танилцуулж тооллого судалгаанд анхаарах асуудал, хэлтсийн цаг үеийн мэдээлэл болон багийн Засаг даргын ажил дүгнэх журмыг танилцуулж ажиллаа.



5. Бусад сурталчилгааны ажил

2018 онд Аймгийн ЗДТГазраас нээлттэй хаалганы өдөрлөгийг аймгийн төвдөө бус сумдад газар дээр нь очиж ажиллах чиглэлийг баримталж ажиллаж байгаа бөгөөд Түмэнд ойрхон –Төрийн үйлчилгээ өдөрлөгийг Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад зохион байгуулахад оролцож иргэдэд статистик мэдээ, тооллого судалгааны үр дүн, өрхийн мэдээллийн санг, мал тооллогын мэдээллийн сан зэргийг танилцуулан ажиллаж нийт 5 сумын 150 гаруй иргэнд мэдээлэл өгч үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаа. 300 инфографик брошур хэвлэн иргэдэд тархааж ажилласан байна.



ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ГБХЗХГазраас зохион байгуулсан баярын жагсаалд хэлтсийн ажилчид оролцон 2017 оны жилийн эцэст гарсан статистик мэдээллийн үр дүнгээр инфографик танилцуулга бэлтгэж хүүхэд багачууд иргэдэд мэдээлэл өгсөн. Мөн статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mnсайтын сонирхолтой статистик булангаас тухайн өдөр төрсөн Сайнцагаан сумын 0-18 насны 21 хүүхдийн батламжийг гаргаж хүүхдүүдээ гардууллаа.



11. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, ВЭБ БАЯЖИЛТ(Ш11)

1.1 Байгууллагын танилцуулга

Хэлтсийн вэб хуудсыг шинэчлэн хууль тогтоомж, Шинэ мэдээлэл, Нийгэм, эдийн мэдээлэл, бидний тухай, Шилэн данс, Ил тод байдал, харилцах хаяг гэсэн 6 цэстэй болгож буцах тэмдэгийг орууллаа. 2018 он гарсаар 22 удаацаг үеийн шинэмэдээ мэдээлэл оруулж, хандалтын тоо жил бүр нэмэгдэж одоогийн байдлаар 335145 хүн хандаж мэдээ тайлан үзсэн нь 2017 оноос 58866 хүнээр нэмэгдсэн байна.Хэлтсийн вэб

хуудсанд “Дундговь аймгийн Статистикийн хэлтэс” нэртэй 1575 гишүүдтэй Page хуудсыг холбож иргэдэд бас үйлчилж байна.

1.2 Бюллетень, танилцуулга

Сар бүрийн бюллетень, танилцуулгыг дараа сарын 12-ны дотор хэлтсийн вэб хуудаст тогтмол байршуулж ирлээ. 2018 оны эхийн хагас жилийн байдлаардизайныг сайжруулж хүснэгтэнд оруулж, 6 удаа шинээ мэдээлэл болон танилцуулгын цэсэнд байршуулаад байна.

Он	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
2014	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	
2015	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	
2016	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах
2017	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах
2018	татах	татах	татах	татах	татах	татах						

1.3 Шинэ мэдээ, мэдээлэл

Сар бүрийн аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгын онцлог мэдээллийг багтаасан хэвлэлийн бага хурлын илтгэлийн файлыг сар бүрийн 13-ны дотор хэлтсийн вэб хуудсанд тогтмол оруулж байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн сар бүрийн хэвлэлийн бага хурал

Он	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
2014	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	
2015	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах
2016	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах
2017	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах	татах
2018	татах	татах	татах	татах	татах	татах						

2.Эмхэтгэл, динамик үзүүлэлт

2.1 Жилийн эмхэтгэл

2017 оны жилийн эцсийн эмхэтгэлийг нэгтгэн 5 сард багтаан хэлтсийн вэб хуудсанд байршууллаа.

2.2 Аймаг, нийслэлийн статистикийн үзүүлэлт

Хүн, малын тоог аймаг байгуулагдсан 1942 оноос хойш динамик хүснэгт үүсгэн орууллаа. Мөн аймгийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтээр динамик хүснэгт хийж байршууллаа. Үүнд:

1. Хүн ам, өрх, нийгмийн зарим үзүүлэлтүүд
2. Хүн ам, өрх багаар
3. Малын тоо, төл бойжилт, хээлтэгч, том малын хорогдол
4. Нийгмийн даатгал
5. Эрүүл мэнд
6. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
7. Бүртгэлтэй ажилгүйчүүд
8. Газар тариалан
9. Барилга
10. Дотоодын нийт бүтээгдэхүүн

№	Үзүүлэлт	байр	2008-2017	татаж авах
1	Хүн ам, өрх, нийгмийн зарим үзүүлэлтүүд			
2	Хүн ам, өрх багаар	баг	2008-2017	татаж авах
3	Малын тоо, төл бойжилт, хээлтэгч, том малын хорогдол	сум	1980-2017	татаж авах
4	Нийгмийн даатгал	сум	2007-2016	татаж авах
5	Эрүүл мэнд	сум	1998-2016	татаж авах
6	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	аймаг	1997-2016	татаж авах
7	Бүртгэлтэй ажилгүйчүүд	сум	2001-2016	татаж авах
8	Газар тариалан	сум	2001-2017	татаж авах
9	Барилга	аймаг	2006-2016	татаж авах
10	Дотоодын нийт бүтээгдэхүүн	аймаг	2000-2016	татаж авах

Аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт төрсөн хүүхдийн тоо, мөнгө банк, нийгмийн даатгал халамж, хөдөө аж ахуй, бүртгэгдсэн гэмт хэрэг, бүртгэлтэй ажилгүй иргэд зэрэг мэдээллээр улирал бүр инфографик хийж хэлтсийн вэб хуудсанд тогтмол байршуулж ажиллалаа. 2018 он гарсаан 1,2-р улирлын инфографикийг хийж хэлтсийн вэб хуудсанд байршуулаад байна.



3. Статистикийн жилийн танилцуулга, судалгаа

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны үзүүлэлтээр заавал хийх 4 танилцуулгыг бэлтгэж 6 сарын 30ны дотор хэлтсийн вэб хуудсанд байршуулан иргэдэд мэдээлэл өглөө. Үүнд:

Аймгийн өрх, хүн амын танилцуулга

Аймгийн хөдөө аж ахуйн салбарын танилцуулга

Аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга

Аймгийн хүн ам, ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга

The screenshot shows the website of the DUNDGOV (Dundgovi) Statistical Center. The header includes the logo and the text "ДУНДГОВЬ ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС". Below the header is a navigation bar with links: "хууль, ТОГТООМЖ", "шинэ мэдээлэл", "нийгэм, эдийн засгийн мэдээлэл", "Бидний тухай", "шилэн данс", "ил тод байдал", "ХАРИЛЦАХ ХАЯГ".

The main content area is titled "Аймгийн нийгэм, эдийн засгийн зарим танилцуулга" (Regional Social and Economic Indicators). It contains a table with the following data:

Танилцуулга нэр	Аймгийн нийгэм, эдийн засгийн сар бүрийн хэвлэлийн бага хурал	
Хөдөө аж ахуйн танилцуулга 2013 он	Аймгийн нийгэм, эдийн засгийн сар бүрийн танилцуулга	
Өрх, Хүн амын төлөв байдал 2013 он	Аймгийн нийгэм, эдийн засгийн зарим танилцуулга	
Аж үйлдвэрийн танилцуулга 2013 он	Инфографик	эх
Ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга 2013	Динамик хүснэгт	эх
Хөдөө аж ахуйн танилцуулга 2014 он	Жилийн эмхэтгэл	эх
Өрх, хүн амын 2014 оны танилцуулга		
Аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулга 2014		
Хүн ам ажил эрхлэлт, ажилгүйдэл 2014		Татаж авах
2015 оны Хөдөө аж ахуйн танилцуулга		Татаж авах
2015 оны Өрх хүн амын танилцуулга		Татаж авах
2015 оны үйлдвэр, барилгын салбарын танилцуулга гарлаа.		Татаж авах
2015 оны Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга гарлаа.		Татаж авах

On the right side, there is a "ТУСЛАХ ЦЭС" (Data Sources) section with icons for "Мэдээний маягт", "Программ хангамж", and "Албан бичиг". Below it, a section titled "ХҮНСНИЙ ГОЛ НЭРГИЙН БАРААНЫ ҮНЭ" (Total Population by Sex and Age) shows data for 2018.09.09:

Хүйс	Тоо
Гурил, 1 зэрэг	1200 кг
Хонины мах	7500 кг
Ухрийн мах	0 кг
Ямааны ястай мах	6800 кг
Элсэн чихэр	2000 кг

Зэрэг мэдээллийг хэлтсийн вэб хуудсанд тогтмол байршуулж ажиллаа. Мөн үндсэн цэснээс гадна мэдээний маягт, 7 хоног бүрийн үнийн мэдээг шинэчлэн сумд болон иргэдэд тогтмол мэдээллээр үйлчилж ирлээ.

IV БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

11. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙНҮЙЛ АЖИЛЛАГАА(Ш12)

Төрийн албаны албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, архив хадгаламжийн нэгжийг "Архивийн тухай" хууль, "Үндэсний статистикийн хорооны архивын журам"-ын дагуу бүрдүүлж байна. Тус хэлтсийн "Хөтлөх хэргийн жагсаалт", "Хадгаламжийн нэгжийн жагсаалт"-ыг гаргаж хугацаанд нь 2018 оны 2 дугаар сарын 13-нд ҮСХ-д хүргүүлж ажиллалаа.

Дундговь аймгийн статистикийн хэлтсийн 2016 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нийт 57 хөтлөх хэрэг байгаагаас байнга хадгалагдах 8, түр хадгалагдах 49 хөтлөх хэрэг байна. Мөн хадгаламжийн нэгж бүртгэлд түр хадгалах бүртгэлд 2006 оноос 2017 оныг хүртэл 01-99 дугаар бүхий 99 нэгж, байнга хадгалах бүртгэлд 2006 оноос 2017 оныг хүртэл 01-52 дугаар бүхий 52 нэгж бүртгэгдсэн байна.


ҮСХороо болон Аймгийн удирдлах байгууллагаас ирсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, хариутай бичгийн хариуг албан тоот бичгээр зохих газарт нь хүргүүлж байна. Цаасаар ирсэн, явсан албан бичиг болон емейл, е-оффисс програмаар ирсэн бичгийг батлагдсан стандартын дагуу хөтөлж байна.

2018 оны эхнээс ирсэн болон явсан бичиг 111 бүртгэгдсэн байгаагаас ирсэн бичиг 77 үүнээс хариутай бичиг 26 байгааг бүртгэлийн картаар тухай бүр бүртгэж, хариуг зохих газарт нь хүргүүлж байсан ба нийт 34 бичиг явсан байна.

Мөн энэ онд гарсан тушаал нийт 13 байгаагаас А тушаал 8, Б тушаал 5 байна. 2018 оны эхнээс ирсэн санал байхгүй хүсэлт 23 бүртгэгдсэнийг бүгдэд нь хариу цаасан болон файл хэлбэрээр хүргүүлээд байна.

13. ШИЛЭН ДАНС (Ш13)

Монгол Улсын “Шилэндансны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган шилэн дансны цахим хуудсанд оруулах ёстой мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулж ажиллалаа. Хэлтсийн санхүү, төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалт, хүний нөөцтэй холбоотой нийт оруулбал зохих 66 мэдээллээс 2018 оны 6 сарын 6-ны байдлаар хугацаа хоцруулсан болон огт оруулаагүй мэдээлэл байхгүй байна. Хугацаандаа оруулсан 57 мэдээлэл, хугацаа болоогүй 9 мэдээлэл байна.




14. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш14)

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэн, анхан шатны бүртгэлүүдийг заавар журмын дагуу хөтөлж, батлагдсан төсвийг зөв зохистой, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр авлага үүсгэхгүйгээр, арвилан хэмнэлтийн бодлогыг тууштай нэвтрүүлэн, 2018 оны эхний хагас жилд санхүүгийн үйл ажиллагаандаа мөн холбогдох хууль, журмыг чанд мөрдөн ажиллаж байна.

Аймгийн аудитын байгууллагаар 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулалт хийлгүүлж, тус хэлтсийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын

тайлангийн дүгнэлтээр зөрчилгүй, “санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна” гэсэн дүгнэлт гарсан.




Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захиралч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хувианы санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнийг хийгүүсэн Сангийн сайдын баталсан журм, заавар дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, ажлын явцын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ГЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДУА-2018/4/СТА-ТШЗ

5

2018 оны эхний 6 сарын байдлаар санхүүгийн 64 ажил гүйлгээ аймгийн санхүү төрийн сангаар дамжин хийгдсэнээс 24 гүйлгээ нь ажиллагсдын цалин хөлс, тэтгэмж, томилолттой холбоотой гүйлгээ байсан. Төсвийн гүйцэтгэлийн болон өр авлагын сарын мэдээг 6 удаа, Нийгмийн даатгалын тайланг НД7, НД8 маягтаар 6 удаа, ХХОАТ-ын тайланг ТТ-11, ТТ-11(1), ТТ-11(2) маягтуудаар 6 удаа тус тус хийж Аймгийн төрийн сан, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Үндэсний Статистикийн хороонд цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Мөн аудитлагдсан тайланг Үндэсний Статистикийн хороонд цахим болон бичгэн хэлбэрээр илгээсэн.

БУСАД ДОТООД АЖИЛ

Нэг. ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн зөвлөлөөс хэлтсийн ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн дунд ширээний теннис болон дартсын тэмцээнийг 5 сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнд хэлтсийн ажилчдын гэр бүл бүрэн хамрагдаж нэгэн үдшийг зөв боловсон өнгөрүүлээ. Мөн тэмцээний үеэр тамхины эсрэг сурталчилгааг хийж тамхигүй гэр бүл, тамхигүй хамт олон болохыг уриалан ажиллалаа.

Хоёр.ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хэлтсийн ажилчдын 0-18 насны хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Тус арга хэмжээний үеэр хүүхдүүдээ аймгийн музейтэй танилцуулж орон нутгийн түүх соёлын үзмэрүүдийг сонирхуулахаас гадна ҮСХ-ны www.1212.mn сайтын сонирхолтой статистик булангаас хүүхэд тус бүрийн регистрийн дугаараар хайлт хийж Монгол улсын хэд дахь иргэн болох батламжийг гаргаж гардууллаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС